



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/395

Алтай хот

**Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн  
Бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах  
тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2022-2023 оны хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах аймгийн нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх ажлыг холбогдох агентлаг, сумын удирдлагуудтай хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг сум, багийн Засаг дарга нар, Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангуулж, дүнг 09 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны  
06 дугаар сарын 27-ний өдрийн 1/25 дугаар  
захирамжийн хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Г.Чинбат (аймгийн Засаг даргын орлогч)  
Гишүүд: Г.Хурцгэрэл (Хөгжлийн бодлого, төлөвлөлт,  
хөрөнгө оруулалтын хэлтсийн  
даргын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч)  
Л.Баянбаатар (Онцгой байдлын газрын дарга)  
Г.Лхагважаргал (Эрүүл мэндийн газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
Д.Наянбуу (Мал эмнэлгийн газрын дарга)  
Н.Сумъяабазар (Мэргэжлийн хяналтын газрын дарга)  
Н.Доной (Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын даргын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч)  
Н.Алтантуяа (Ус, цаг уур, орчны шинжилгээний  
төвийн дарга)  
(Сумын Засаг дарга нар)  
Нарийн бичгийн дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
даргын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч)